



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АКТ

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IY байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.03.25 № 1/16

Үлдэгдэл төвлөрүүлэх тухай

МОНГОЛ УЛСААС ИХ БРИТАНИ,
УМАРД ИРЛАНДЫН ВАНТ УЛСАД
СУУГАА ОНЦ БӨГӨӨД БҮРЭН
ЭРХТ ЭЛЧИН САЙД Н.ТУЛГА
ТАНАА

Монгол Улсаас Их британи, умард ирландын вант улсад суугаа Элчин сайдын яамны 2012 он, 2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын явцаддараах зөрчил илэрлээ.

Тус ЭСЯ нь өөрийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 2012 онд 0.3 мянган ам доллараар, 2013 онд 22.3 мянган ам доллараар давуулан биелүүлж, төсвийн зардлыг 2012 онд 0.3 мянган ам.доллараар, 2013 онд 29.5 мянган ам.доллараар тус тус хэмнэлттэй зарцуулжээ.

Харилцах дансны 2013 оны 22,353.54 ам.долларын эцсийн үлдэгдлийг Төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 7.7-д "Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т заасан "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулахын тулд акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын заалтуудыг үндэслэн
ТОГТООХ НЬ:

Дээрх 22,353.54 ам. долларын эцсийн үлдэгдлийг 2014 оны 6 дугаар сарын 15-ны дотор улсын төсөвт төвлөрүүлэн, биелэлтийг 2014 оны 7 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Онц бөгөөд бүрэн эрхт Элчин сайд Н.Тулга, нягтлан бодогч Д.Намуунбилэг нартхариуцуулав.

АКТ

ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ДАРГА

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ
ЭЛЧИН САЙД

С.ЭНХЗАЯ
АУДИТОР Д.УРТНАСАН
УХА0122

Н.ТУЛГА
НЯГТЛАН БОДОГЧ
Д.НАМУУНБИЛЭГ